

93

**“ДАРХАН ХҮНС” ХК-НИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРАЛД ОРОЛЦОХ ЭРХ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД
ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧИГ**

“ДАРХАН ХҮНС” ХК-ийн 2014 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах болсонтой холбогдуулан тус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд дараах бичиг баримтыг танилцуулна.

1. “ДАРХАН ХҮНС” ХК-ийн 2014 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэр, хавсралтууд
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг
3. ДАРХАН ХҮНС” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах хуудсын загвар
4. Компанийн 2014 оны санхүүгийн болон аудитын тайлан
5. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдийн танилцуулга
6. “ДАРХАН ХҮНС”ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслүүд

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Хавсралт 1

"ДАРХАН ХҮНС" ХК-ийн 2014 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын олон нийтэд мэдээллэх зарын загвар

"ДАРХАН ХҮНС" ХК ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН АНХААРАЛД:

" ДАРХАН ХҮНС" ХК-ийн хувь нийлүүлэгчдийн ээлжит хурал 2015 оны 04-р сарын 24-ны өдрийн Баасан гаригийн, 14.00 цагт "ДАРХАН ХҮНС" ХК-ийн төв байрны хурлын зааланд болно.

Хаяг: Дархан уул аймаг Дархан сум 5-р баг "Дархан Хүнс" ХК-ны байр

Хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ:

- Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-аас гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- Компанийн 2015 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэж батлах
- Бусад

Бүртгэх өдөр компанийн хувьцааг эзэмшиж буй иргэд болон ААН –үүд хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаар танилцуулах материал, саналын хуудсыг харилцагч брокерийн дилерийн компаниудаас авч танилцах боломжтой.

Олон нийтэд зарлах огноо: 2015 оны 03-р сарын 17

Бүртгэх өдөр: 2015 оны 03-р сарын 27

Хурал зохион байгуулагч:

"ДАРХАН ХҮНС" ХК

(дарга) Утас: 9994-6499, И-мэйл: tunga_1026@yahoo.com

(гишүүдийн) Утас: 9937-3805, И-мэйл: muugii0513@yahoo.com

“ДАРХАН ХҮНС” ХК-ийн 2014 оны Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит хурлын дэг:

- Хурлын ирцийг бүртгэх 14.00-14.20
- Хурлын ирцийг мэдээлэх 5 минут
- Хурлын даргыг сонгох, хурал удирдах бүрэлдэхүүнийг сонгох 10 минут
- Тооллогын комиссын даргыг сонгох 5 минут
- Хурлын дарга хурлыг удирдаж, хурлаар хэлэлцэх асуудлын дэгийг танилцуулж батлах 10 минут
- Хурлын дэгийн дагуу хурлаар хэлэлцэх асуудлыг хэлэлцэх:
 - ✓ Компаний 2014 оны үйл ажиллагааны үр дүн, цаашдын зорилтын тухай.
/гүйцэтгэх захирал А.Тунгалаг Хугацаа 20 минут/
 - ✓ Компаний 2014 оны санхүүгийн үйл ажиллагааны тухай, тайлан тэнцлийн дүнгийн тухай.
/ерөнхий нягтлан бодогч Б.Төрмөнх угацаа 20 минут/
 - ✓ “Дархан Хүнс” ХК ны 2014 оны санхүүгийн үйл ажиллагаанд өгөх үнэлэлт дүгнэлт /хянан шалгагч Д.Цэцэгбадрал Хугацаа 20 минут /
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох /хурлын дарга/
- Компанийн бизнес төлөвлөгөө
2015 онд үр ашигтай ажиллах, ашгийг нэмэгдүүлэх зорилгоор хийгдсэн бизнес төлөвлөгөө, цаашдын үйл ажиллагааны тухай мэдээлэл /Гүйцэтгэх захирал А.Тунгалаг/
- Тооллогын комисс байгуулах /Хурлын дарга/
- Компаний хяналтын зөвлөлийг сонгох /Хурлын дарга/
- Бусад асуудал /Хурлын дарга/
- Асуулт, хариулт /Хувьцаа эзэмшигчид сонирхсон асуултаа асуух/
- Хувьцаа эзэмшигчид үг хэлэх, санал гаргах
- Хурлын дарга хурлыг хааж үг хэлэх

Жич: Хувьцаа эзэмшигчид та бүхнийг хуралдаа идэвхтэй оролцож, хурлын цагаас хоцрохгүй хүрэлцэн ирэхийг хүсье. Хуралтай холбоотой асуудлаар тодруулах зүйл байвал 9994-6499 утсаар холбогдож лавлана уу.

хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээллийн жагсаалт

Хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ:

- Компаний 2014 оны үйл ажиллагааны үр дүн, цаашдын зорилтын тухай.
/гүйцэтгэх захирал А.Тунгалаг, хугацаа 20 минут/
- Компаний 2014 оны санхүүгийн үйл ажиллагааны тухай, тайлан тэнцлийн дүнгийн тухай.
/ерөнхий нягтлан бодогч Б.Төрмөнх, хугацаа 20 минут/
- “Дархан Хүнс” ХК ны 2014 оны санхүүгийн үйл ажиллагаанд өгөх үнэлэлт дүгнэлт
/хянан шалгагч Д.Цэцэгбадрал/
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
/хурлын дарга/
- Компанийн бизнес төлөвлөгөө 2015 онд үр ашигтай ажиллах, ашгийг нэмэгдүүлэх зорилгоор хийгдсэн бизнес төлөвлөгөө, цаашдын үйл ажиллагааны тухай мэдээлэл
/Гүйцэтгэх захирал А.Тунгалаг/
- Тооллогын комисс байгуулах
/Хурлын дарга/
- Компаний хяналтын зөвлөлийг сонгох
/Хурлын дарга/
- Бусад асуудал
/Хурлын дарга/



2015 оны 03 сарын 12 өдөр

№ 15/02

Монгол улс
Дархан хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Компаний тухай хуулийн 60 дугаар зүйл, 64.2 дахь заалт, компаний дүрмийн 7.3 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Хувьцаат компанийн хувь нийлүүлэгчдийн хурлын зар мэдээг хүргэх журмын 2.1, 2.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “ДАРХАН ХҮНС” ХК-ний 2014 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2015 оны 04-р сарын 24-ны өдрийн 14⁰⁰ цагт Дархан уул аймаг, Дархан сум 5-р баг “Дархан Хүнс” ХК-ны байранд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2015 оны 03 р сарын 27-ний өдрөөр тогтоосугай.
3. “ДАРХАН ХҮНС” ХК-ний 2014 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 - Компаний 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-аас гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
 - Компаний Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
 - Компаний 2015 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэж батлах
 - Бусад асуудал
4. “ДАРХАН ХҮНС” ХК-ний 2014 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах болсонтой холбогдуулан тус хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдэд дараахь бичиг баримтыг хурал хуралдахаас өмнө танилцуулах ажлыг зохион байгуулсугай. Үүнд:
 - “ДАРХАН ХҮНС” ХК-ийн 2014 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэр, хавсралтууд
 - Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг
 - ДАРХАН ХҮНС” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах хуудсын загвар
 - Компанийн 2014 оны санхүүгийн болон аудитын тайлан
 - Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдийн танилцуулга
 - “ДАРХАН ХҮНС” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслүүд
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг Хавсралт 3-аар баталсугай
6. Ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ны агуулгыг Хавсралт 4-өөр баталсугай.

7. Компанийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлаар Санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг хурал хуралдах өдрийн буюу 2015.04.24-ний өдрийн 14⁰⁰ цагаар тасалбар болгосугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тухай зарыг 2014 оны 03 дугаар сарын 17-нд болон үүнээс 15 хоногийн дараа өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр давтан нийтлэх, Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас дээр тавих, брокерийн компанид хүргүүлэх зэргээр хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссийн даргаар Гүйцэтгэх Захирал А.Тунгалаг, гишүүнээр ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Д.Мөнхцэцэгийг, Тооллогын комиссийн даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Т.Цэвэгмэдийг, гишүүнээр ТУЗ-н дэргэдэх дотоод аудит, хянан шалгагч Цэцэгбадрал нарыг тус тус томилсугай.
10. “ДАРХАН ХҮНС” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг Санхүүгийн Зохицуулах Хороо, “Монголын Хөрөнгийн Бирж” ХК-д хүргүүлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**



Б.БАТ-ӨЛЗИЙ

Хаяг: Монгол улс, Дархан-Уул аймаг, 5-р баг
Шуудангийн хайрцаг: № 259
Утас: 976-7037-7746
Факс: 976- 7037-7747
□□□: darkhankhuns.com